



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.5.1 дэх заалтыг үндэслэн Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийг бууруулах тухай нийтийн өргөдлийг судалж, шийдвэрлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т даалгасугай:

1/нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын тэнцвэртэй байдлыг алдагдуулалгүйгээр зарим даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг уян хатан тогтоох боломжийг судалж, холбогдох хуулийн төсөлд тусган боловсруулж Монгол Улсын Их Хуралд 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

2/нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг төлөвшүүлж, нийгмийн даатгалын сангаас “Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагч, “Чингис хаан” банк ХХК-иас нэхэмжилсэн авлагыг барагдуулах арга хэмжээг яаралтай авч санг алдагдалгүй түвшинд хүргэх;

3/даатгуулагчид ирэх санхүүгийн ачааллыг бууруулах хүрээнд тэтгэврийн зардлыг Үндэсний баялгийн сангаас санхүүжүүлэх боломжийг судалж, танилцуулах.

2. Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Г.Занданшатар)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо (Л.Энхнасан)-нд даалгасугай.

НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Л.ЭНХНАСАН

